

2015.11.06 № 05/559  
танай \_\_\_\_\_ -ны \_\_\_\_\_ -т

Албан бичгийн хариу хүргүүлэх тухай

ХЭГ/1676 тоот албан бичгийн хариуг Танд үүгээр хүргүүлж байна.

"Эрдэнэс Монгол" ХХК нь холбогдох хууль тогтоомжийн дагуу төсөвт албан татвар, төлбөр хураамж төлөх замаар төрийн санхүүгийн үйл ажиллагаанд оролцдог ба Хүний хөгжил сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хөрөнгө төвлөрүүлэхтэй холбогдох санхүүгийн харилцааг "Хүний хөгжил сан"-ийн тухай хуулиар тусгайлан зохицуулсан болно.

"Хүний хөгжил сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу "Эрдэнэс Монгол" ХХК нь "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших эрхийг төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу тус санд хөрөнгө төвлөрүүлэх үндсэн чиг үүрэгтэй хуулийн этгээд ба тус хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу "Сангийн хөрөнгийн ерөнхий удирдлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ." гэснээр сангийн яам нь санд төвлөрсөн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий субъект юм.

Нэгэнт "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааг "Хүний хөгжил сан"-ийн тухай хуулиар, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох бусад харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулдаг тул "Засгийн газар, Төрийн өмчит аж ахуйн нэгж хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан журам" боловсруулан хэрэгжүүлэх нь "Төр-төрийн өмчит компани" хоорондын эрх зүйн харилцааг улам төвөгтэй болгосон, хууль зүйн хувьд ойлгомжгүй байдал үүсгэх талтай юм.

"Эрдэнэс-Монгол" ХХК нь "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга"-ийг байнга дэмжин ажиллаж үйл ажиллагаандаа хэвшүүлэх тал дээр анхааран ажилладаг бөгөөд 2015 оны 1 дүгээр сарын 1-ээс "Шилэн данс"-ны тухай хуулийг мөрдөн ажиллаж буйгаа үүгээр уламжилж байна.

Таныг хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН АЖЛЫН  
АЛБА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ



Ч.ОТГОЧУЛУУ